



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРОО**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2015.01.27 № 7/763

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Мэдээлэл ирүүлэх тухай**

Хууль зүйн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Архивын ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Гаалийн ерөнхий газар зэрэг байгууллагуудын ахмадын хороо, ажиллагсдын төлөөллөөс Улсын Их Хурал дахь намын бүлгүүдэд хандаж Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийг /хуучин нэрээр/ дахин байгуулж, эмнэлгийн зориулалтаар баригдсан барилгын талаар өргөдөл гаргасныг тус Байнгын хороонд ирүүлжээ.

Засгийн газрын 2012 оны 122 дугаар тогтоолоор Хууль зүйн яамны харьяа “Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг”, Батлан хамгаалах яамны харьяа “Зэвсэгт хүчний клиникийн төв госпиталь”-ыг нэгтгэн “Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэг” болгон өөрчлөн зохион байгуулан Батлан хамгаалах яамны харьяанд ажиллуулж, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн зориулалтаар барьж байгаа барилгыг Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газрын мөрдөн байцаах асуудал хариуцсан байгууллагын албан контор, шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын нэгдсэн цахим мэдээлэл болон иргэдэд хууль зүйн үйлчилгээ үзүүлэх төвийн зориулалтаар өөрчлөн засаж, тус тус балансад нь шилжүүлэх шийдвэр гаргасан. Засгийн газрыг энэ шийдвэрээ өөрчлөн эмнэлгийн барилгыг зориулалтын дагуу ашиглах шаардлагыг эмнэлгийн ажилтнууд, төрийн тусгай албан хаагчид, иргэд, нэр бүхий Улсын Их Хурлын гишүүд өнөөдрийг хүртэл тавьсаар ирсэн.

Улсын Их Хурлын 2014 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Засгийн газрын гишүүдийг томилох асуудал хэлэлцүүлэхэд Хууль зүйн сайдад нэр дэвшигч Та Төрийн тусгай албан хаагчдын эмнэлгийн /хуучин нэрээр/ барилгын талаар судлан үзэж Засгийн газарт танилцуулахаар мэдэгдсэн. Иймд энэ ажлын явц байдал, цаашид авах арга хэмжээний талаарх мэдээллийг 2015 оны 02 дугаар сарын 01-ний дотор Байнгын хороонд ирүүлнэ үү.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн Ажлын албаны албан бичиг, нэр бүхий байгууллагуудын ахмадын хороо, ажиллагсдын төлөөллөөс ирүүлсэн өргөдлийг хавсаргав. Хавсралт 16 хуудастай.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

О.БААСАНХҮҮ

0000000393